

Мэдээллийг үнэлэх

# Одоогоор та дараах зүйлсийг сурч мэдсэн байгаа

- Мэдээллийн хэрэгцээгээ тодорхойлж сурсан (Алхам 1)
- Хайлтын стратеги боловсруулах болон хайлтыг үр дүнтэй болгох хэрэгслүүдийг ашиглах (Алхам 2)
- Хайлт хийх эх сурвалж сонгох (Алхам 3)
- Мэдээллийг эрж олох (Алхам 4)

# Мэдээлэл үнэлэх

Таны олсон мэдээлэл найдвартай, судалж буй зүйлсэд хамааралтай эсэхийг хэрхэн мэдэх вэ?

Иймээс та олж авсан эх сувралж, мэдээллээ үнэлэх хэрэгтэй.

Хайлтын үр дүнд маш олон мэдээллийг олж болох ч эдгээр нь бүгд чанартай мэдээлэл байх албагүй.

**ЧАНАР** нь **ТООНООС** хамаагүй илүү.

# Мэдээлэл үнэлэх

Таны сонгосон мэдээллийн эх сурвалж нь таны ажил болон судалгааны үр дүнд нөлөөлөх боломжтой.

Иймээс олж авсан мэдээлэл тань үнэн зөв, судалгааны ажилд хамааралтай, чанартай байлгахын тулд та тэдгээрийг үнэлэх хэрэгтэй.

Мэдээллийг үнэлэхдээ дараах 5 шалгуурыг харгалзан үзэх нь чухал:

# №1 Authority - Нэр сүр - Баталгаа нь юу вэ?

- Зохиогч нь хэн бэ? Энэ хүн тухайн салбартаа мэргэшсэн хүн мөн үү?
- Өөр бусад зохиогчид эш татсан уу?
- Өөр бусад өгүүлэл/ном бичсэн үү?
- Нийтлэгч нь хэн бэ?
- Тухайн эх сурвалж нь баталгаатай вэб сайт дээр байна уу?  
Жнь: Боловсролын сайт(.edu), засгийн газрын сайт (.gov)
- Энэ салбарын бусад зохиогчдын нэрийг бичсэн үү?

## №2 Currency - Үнэ цэнэ - Хугацаа

- Ашиглах гэж буй тухайн нийтлэл/ном хэзээ хэвлэгдсэн бэ?
- Нийтлэгдсэн огноо нь таны хэрэгцээнд нийцэж байна уу?
- Танд одоогийн болон түүхэн мэдээлэл хэрэгтэй юу?
- Уг ном/нийтлэлд эш татсан эх сурвалжууд хэдий үеийнх вэ?

## №3 Content - Агуулга

- Тухайн мэдээлэл таны судалж буй сэдэвтэй хамааралтай юу?
- Зорилтот хэрэглэгчдэд тохиромжтой юу?
- Бичвэр нь эрдэм шинжилгээний хэл найруулгаар бичигдсэн үү?  
Ойлгохын тулд өөр илүү материал хэрэгтэй юу?
- Мэдээлэл нь баримтат уу, хуурамч уу, эсвэл хошин егөөдөл үү?
- Сэдвийг гүнзгийрүүлэн судалсан уу, эсвл хязгаарлагдмал хүрээг хамарсан уу?
- Мэдээлэл нь таны сэдэвт хэр чухал вэ?

## №4 Accuracy - Нарийвчлал

- Уг мэдээллийг таны удирдагч (багш) тань сайн эх сурвалж гэж зөвлөсөн үү?
- Судалгааны арга зүйн талаар хангалттай тайлбартай юу?
- Өөр бусад эх сурвалж ашиглан мэдээллийг баталгаажуулах боломжтой юу?
- Ном зүйд тусгагдсан зохиогчдыг та таньж байгаа юу?
- Ном/өгүүлэлд байгаа холбоосууд нь ном зүй болон өөр эх сурвалжид холбогдож байна уу?
- Тухайн салбарын өөр бусад шинжээчид энэ мэдээллийг хянаж үзсэн үү?
- Тухайн мэдээлэл байгаа вэбсайттай холбоотой бусад вэбсайтад та итгэдэг үү?
- Мэргэжлийн өөр сэтгүүлд ямар нэг сэтгэгдэл байгааг эрж хайсан уу?



## №5 Bias - Хазайлт - Зөрүү

- Зохиогч нь сэдэв хазайхуйц тодорхой байгууллагатай хамааралтай байна уу?
- Уг судалгааг ямар нэг байгууллага ивээн тэтгэсэн үү? (Захиалгатай эсэх)
- Зохиогч нь аль нэг бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдаж авахыг санал болгож байна уу?
- Бусад зохиогчид уг зохиогчийн үзэл баримтлалтай санал нийлж байна уу?

# Дасгал

“Шоколад танд аз жаргал өгдөг” гэсэн сэдвээр ярилцах.

Шоколадны нөлөөллийн талаар олж мэдсэн мэдээллээ дараах шалгуурын дагуу үнэлэх:

- **Зохиогчийг үнэлэх**
  - Энэ салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн үү? Энэ талаар өөр ямар эх сурвалж байна? Сэтгэл судлал, биологи, эрүүл мэнд талаар мэргэшсэн хүн үү?
- **Хэвлэгдсэн огноог шалга**
  - Эш татсан мэдээллийн огноог шалга. Хэзээ хэвлэгдсэн мэдээлэл вэ?
- **Агуулгыг талаарх шүүмж**
  - Эрдэм шинжилгээний хэл найруулгаар бичигдсэн үү? Таны сонирхсон мэдээлэлтэй нийцэж байна уу?
- **Нарийвлал хийх**
  - Ямар нэг дүрмийн алдаа байна уу? Энэ мэдээллийг өөр хэн хүлээн зөвшөөрч байна? Эх сурвалжид байгаа жагсаалт руу орж шалгасан уу?
- **Зөрүүг тодорхойл**
  - Бусад зохиогчдын үр дүн, дүгнэлттэ йтохирч байна уу? Аль нэг байгууллагын захиалгат судалгаа юу? Зохиогчийн өөрийн байр суурь энд нөлөөлсөн үү? Зохиогч нь бодит баримт ашигласан уу?